



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22-дөр

Дугаар А/397

Ховд

Үйлчилгээний байгууллагуудын цагийн
хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “ж”, “л” заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирусийн /Covid-19/ тархалтаас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг үйлчилгээний төв, дэлгүүр, баар, караоке, ресторан, кафе, зоогийн газруудыг 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн түр хугацаанд 08.00 цагаас 23.00 цагийн хооронд үйл ажиллагаа явуулахаар цагийн хуваарийг өөрчлөн тогтоосугай.

2. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/247 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН